



СОЁЛЫН ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Санхүүгийн аудит
Хамрагдсан байгууллага: “Монголын үндэсний музей”
Шалгалтын тайлангийн код: ХШҮДАГ-2024/ДА/07

Аудитын дүгнэлт:

Монголын үндэсний музейн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын дүнгээр илэрсэн хууль, тогтоомжийг зөрчсөн үйлдэл, алдаа, дутагдалд үндэслэн байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг “Хангалтгүй” гэж дүгнэв.

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР1

1.ТАНИЛЦУУЛГА.....2

1.1. Байгууллагын тухай.....2

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ2

2.1. Аудитын зорилго:2

2.3. Аудитын арга, аргачлал3

2.4. Өмнөх шалгалтын талаар3

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ.....4

3.1. Засаглалын удирдлагын талаар4

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар4

3.3. Дотоод хяналтын талаар5

4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар5

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ7

6. ЗӨВЛӨМЖ7

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ДА	Дотоод аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
АБ	Аудитын баримт

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7.2, 7.3 дахь заалт, Соёлын сайдын 2021 оны А/43 дугаар тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”, Соёлын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Соёлын сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ХШҮДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл, шинжээч Ц.Алтанхуяг нар санхүүгийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Байгууллагын регистрийн дугаар 9081569, үндсэн үйл ажиллагааны 100-9000-34011, нэмэлт санхүүжилтийн 100-9000-34411 тоот харилцах данс, Голомт банк дахь 1105-439-891 дугаартай дансаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аудитын хамрах хугацаанд захирал Л.Жаргал асан 2022 оны 10 дугаар сараас 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл, Соёлын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/40 дүгээр тушаалаар захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхтогоо 2023 оны 11 дүгээр сарын 08-аас 2024 оны 03 дугаар сарын 23 ны өдрийг дуустал нэгдүгээр гарын үсгийг зурсан байна.

Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Б/89 дүгээр тушаалаар ахлан нягтлан бодогчоор томилогдсон Э.Одончимэг 2024 оны эхнээс 09 дүгээр сарын 01-ны өдөр хүртэл, Захирлын Б/126 дугаар тушаалаар томилогдсон ахлах нягтлан бодогч Д.Батцэцэг 2023 оны 09 дүгээр сарын 01 –ний өдрөөс эхлэн санхүүгийн жил дуустал 2 дугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2023 оны санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

Бүтэц зохион байгуулалт

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2014 оны Б/18 дугаар тушаалын “Үндэсний музейн дүрэм”, орон тооны дээд хязгаарыг 61 байхаар тогтоосон.

Засаглах удирдлага: Захирлын дэргэд 6 зөвлөл ажилладаг. Үүнд: Эрдмийн зөвлөл, Мэргэжил-арга зүйн зөвлөл, Захиргааны зөвлөл, Сан хөмрөгийн зөвлөл, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Ёс зүйн зөвлөл

Гүйцэтгэх удирдлага: Хэлтэс-1, алба -3, төв -2 гэсэн бүтэцтэй, нийт 61 орон тоотой.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийн

дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Аудитын хамрах хүрээг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тус газраас гүйцэтгэсэн дотоод аудитын тайлангийн хамарсан хүрээгээр хязгаарлав.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллага нь өмнөх хугацаанд яамны дотоод аудитын нэгжийн 2022 оны төлөвлөгөөт аудитад хамрагдаж “дунд” эрсдэлтэй байгууллагаар үнэлэгдсэн тул энэ удаа давтан аудитад хамрагдаж байгаа болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 923.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 7,149.2 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг УАГ-аас хянаж хангалттай гэж үнэлсэн байна.

Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинэ баланс Аудит” ХХК нь тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэн “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитын тайлангаар гадаад улсад ажиллаж байгаа эрдэм шинжилгээний ажилтанд 1,680.0 мянган төгрөгийн хоол болон унааны мөнгө олгосон, сахилгын шийтгэл ногдуулсан эрдэм шинжилгээний ажилтанд журам зөрчиж 530.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 561.0 мянган төгрөгийн шагналт цалинг олгосон тул нөхөн төлбөрийн 2 акт тогтоосон байна.

Мөн цаашид анхаарвал зохих дараах асуудлаар зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:

- Бараа материалын бүртгэлтэй холбоотой анхан шатны баримтгүйгээр 8,400.0 мянган төгрөгийн барааг зарцуулсан.
- Босго үнээс давсан өртөгтэй бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ болон бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахдаа байгууллагуудаас үнийн санал авч харьцуулалт хийгээгүй, хийгдэх ажлын төлөвлөгөө хөтөлбөрийг гэрээнд нарийвчлан тусгаагүй, хийсэн ажлын тайлан бүрэн бус, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй.
- Байгууллага нь 61 ажилтны батлагдсан орон тоотой боловч тайлант онд ажлын байранд шаардлагатай ажилтан авалгүй хавсран гүйцэтгэх байдлаар нийт 47-55 ажилтан ажилласан байна. Тухайлбал: Ерөнхий нягтлан бодогч нь тооцооны нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь санхүүгийн дотоод хяналтыг сулруулж байна гэж үзжээ.

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Тус байгууллагын захирлын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/55 дугаар тушаалаар “Монголын үндэсний музейн хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2023 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 172, боловсон хүчний чиглэлээр 191 нийт 363 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулгаар судалгаа хийж дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулгаар судалгаа хийж, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын чиглэлээр 2022 онд 5 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, төрийн өмчийн улсын үзлэг тооллогыг ажлыг байгууллагын хэмжээнд сайн зохион байгуулж дотоод хяналтын шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,017,664.0 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл зардлыг 98,930.9 мянган төгрөг, ажил олгогчоос НДШ-ийн зардлыг 12,366.5 мянган төгрөг, ашиглалтын зардлыг 37,287.1 төгрөг мянган, хангамж бараа материалын зардлыг 48,460.0 мянган төгрөг, норматив зардлыг 1,381.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 192,658.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 380,633.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 52,964.7 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 52,272.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,140,708.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр баталсан 241 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” тогтоолын дагуу цалин, нэмэгдэл хөлсийг 428,478.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Соёл урлаг” хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал 1,569,186.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,569,186.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,542,762.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 26,423.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,542,762.8 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлын төсвийг 26,283.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 140.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,362,535.1	1,338,732.4	23,802.70	98.3
2	80214 Уран бүтээл хийлгэх	3,098.0	3,098.0	-	100.0
3	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны	5,422.5	5,422.5	-	100.0
4	80219 Харуул, хамгаалалтын зардал	12,705.4	10,232.9	2,472.50	80.5
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	36,527.6	36,387.1	140.50	99.6

6	81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	137,941.5	137,941.5	-	100.0
7	81909 Музей, түүх, соёлын өвийн сэргийлэх	418.0	410.0	8.00	98.1
8	81938 Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	10,538.4	10,538.4	-	100.0

Нэмэлт төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны захирагчаас хуваарилсан 276,523.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 908,888.0 мянган төгрөг, “Гүнбүрд онгон цогцолборын шинжлэх ухааны судалгааны төсөл”-ийн татаас санхүүжилтийн авлага 13,221.8 мянган төгрөг, нийт 1,185,411.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 926,148.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 259,243.2 мянган төгрөгийг зарцуулж, 24,900.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэн арилжааны банканд 20.0 мянган төгрөг үлдсэн байна.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 295,269.2 мянган төгрөгөөр буюу 3,17 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	20.0	20.0
Авлага	13,241.8	-	(13,241.8)
Урьдчилгаа	-	9,240.0	9,240.0
Бараа материал	408,310.8	485,618.5	77,307.7
Үндсэн хөрөнгө	8,898,485.3	9,120,428.6	221,943.3
Нийт хөрөнгө	9,320,037.9	9,615,307.1	295,269.2
Богино хугацаат өр төлбөр	13,241.8	-	(13,241.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,306,796.1	9,615,307.1	308,511.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,320,037.9	9,615,307.1	295,269.2

Бараа материалын дансны үлдэгдэл 485,618.5 мянган төгрөг болж 77,307.7 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,120,428.6 мянган төгрөг болж 221,269.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,615,307.1 мянган төгрөг болж, 308,511.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн болон богино хугацаат өр төлбөр 13,241.8 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монголын үндэсний музейн 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын дүнгээр илэрсэн хууль, тогтоомжийг зөрчсөн үйлдэл, алдаа, дутагдалд үндэслэн байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг “Хангалтгүй” гэж дүгнэв.

Аудитаар илэрсэн 66,471.0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагыг хэрэгжүүлж, тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШҮДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

6. ЗӨВЛӨМЖ

Төсвийн шууд захирагч, захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхбат, ахлах нягтлан бодогч Д.Батцэцэг нарт		Хугацаа
Зөвлөмж 1.	Захирамжлалын баримт бичгийн үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэлийг тодорхой тусгаж байх;	2024 оны 011-р сарын 25-ны дотор
Зөвлөмж 2.	Албан томилолтын удирдамж, үнэмлэх, томилолтын ажлын тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдлийг хангаж зардлыг олгож байх;	
Зөвлөмж 3.	Албан томилолтоор ажилласан хугацаанд байгууллагаас олгодог унаа хоолны хөнгөлөлтийг олгохгүй байх;	
Зөвлөмж 4.	Улирлын үр дүнгийн урамшууллыг журамд заасан хязгаараас хэтрүүлэхгүйгээр олгох шийдвэр гаргаж, түүний дагуу олгож байх;	
Зөвлөмж 5.	Захиргааны шийтгэл хүлээсэн, шийтгэлтэй хугацаа дуусаагүй албан хаагчдад аливаа урамшуулал олгохгүй байх;	
Зөвлөмж 6.	Холбогдох албан хаагчдад журамд заасан хязгаарт багтаан илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгож байх;	

СОЁЛЫН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---oOo---